



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн тушаах нь:

1. Цэрэн овогтой Отгонбилэгийг АНУ-ын Соүф Дакотагийн Уул уурхай, технологийн сургуулийн магистрантурт технологийн удирдлагын чиглэлээр, Багмид овогтой Оюунчимэгийг Канад улсын Сайнт Маригийн Их сургуулийн магистрантурт олон улсын хөгжлийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасурэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Сайд  
TS

А.ЦАНЖИД

Хүрэлдээр чит; с/м

З.Жижигийн  
2002.11.29